



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/68

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Худалдаа хөгжлийн банк” ХХК (2635534)-ийн эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг (Хэрлэн), Тэмүүжин гудамжинд байрлах, үйлчилгээний зориулалттай 1222 м² газрыг иргэн О.Уянга (СЮ02321840)-д 43 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Иргэн О.Уянга эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн цахим гэрчилгээг олгон гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн О.Уянгад үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны А/122 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ